



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот

7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090

Утас: 70592439, 70592208, 70593208

И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2023 09 26 № 02/158

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ЛУУС СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.ӨЛЗИЙХИШИГ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, зарцуулалт, захиалагчийн хяналттай холбоотой зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг арилган, заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт.....<sup>6</sup> хуудас

ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

0012032624



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 210.

А/1260315

Мандалговь

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитаар 2022 онд дутуу хийгдсэн "Ахуйн үйлчилгээний барилга" -ын ажлын төсвийн зарцуулагдаагүй **34,263,714.00** /Гучин дөрвөн сая хоёр зуун жаран гурван мянга долоон зуун арван дөрөв/ төгрөгийн үлдэгдлийг ОНХС-ийн 2023 оны төсвийн эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулалгүй, зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.27.-д /"орон нутгийн төсөв" гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Толоологчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;/, 60.3.6.-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;/, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай" журмын 4 дүгээр зүйлийн 4.3.6-д /ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хоронго оруулалт, хотолбор, тосол, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. 2022 онд дутуу хийгдсэн "Ахуйн үйлчилгээний барилга" -ын ажлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн тодотголоор сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад нэмж тусган ИТХ-аар батлуулан зарцуулах.

0012042005

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Луус сумын Засаг дарга Б.Өлзийхишиг, Санхүүгийн албаны дарга Б.Доржханд, нягтлан бодогч Э.Сумьяажаргал нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**


АХЛАХ АУДИТОР

 /Д.ИХБАЯР/

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Р.МӨНХТОГТОХ

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 209

A/126 УЗ15

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитаар сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн **"Төв саадын тохижилт, засвар"**, **"Спорт талбайн тохижилт"**, **"Хөдөөгийн 3 багт Мал угаалгын банн шинээр барих"**, **"Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт"**-ын ажлын захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй **2,697,458.00 /Хоёр сая зургаан зуун ерэн долоон мянга дөрвөн зуун тавин найм/** төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т *барилгын үе шатын ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах/*, Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.12-т *улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно/*, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах арга хэмжээний" тухай А/407 дугаар захирамжийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. 2023 онд төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжүүлж эхлээгүй болон хэрэгжиж эхэлсэн боловч дуусаагүй ажлын хяналтыг хууль, журмын дагуу гүйцэтгүүлж зөрчлийг арилгах.
2. Цаашид Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах;

0012042002



Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Луус сумын Засаг дарга Б.Өлзийхишиг, Засаг даргын орлогч Э.Энхжаргал, Санхүүгийн албаны дарга Б.Доржханд, нягтлан бодогч Э.Сумьяажаргал нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР

ДИХБАЯР

**БАТАЛГААЖУУЛСАН**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

---

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 211

A/1260315

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Луус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитаар “Хөдөөгийн 3 багт Мал угаалгын банн шинээр барих” 3 багц ажлын тендер шалгаруулалтын хууль, журмын дагуу зохион байгуулаагүй **95,550,270.00** /Ерэн таван сая таван зуун тавин мянга хоёр зуун дал/ төгрөгийн зөрчил илэрлээ. /“Мал угаалгын банн шинээр барих ажил”-ыг газар зүйн байрлалыг харгалзан 3 багц болгон хуваасан боловч тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгоогүй./

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.4. /хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;/ Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.6. /Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ажил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно./, 8.7.1. /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,тайлагнах журам”-ын 4.8.3. /Захиалагч нь төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт өртөгт багтаан холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах үүрэгтэй;/, 4.8.31. /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхгүй;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зорчсон, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, санхүүжүүлж байх.

0012042008

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Луус сумын Засаг дарга Б.Өлзийхишиг, Засаг даргын орлогч Э.Энхжаргал, Санхүүгийн албаны дарга Б.Доржханд, нягтлан бодогч Э.Сумьяажаргал нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР

/Д.ИХБАЯР/

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

---

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Луус сумын Орон нутгийн хөгжлийн сан  
Тайлант хугацаа: 2023 оны 2 дугаар улирал

№	Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн төвч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	10
1	Хөрөнгийн зардал	2022 онд дутуу хийгдсэн "Ахуйн үйлчилгээний барилга" -ын ажлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг ОНХС-ийн 2023 оны төсвийн эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулалгүй, зарцуулсан.	34,263,714.00	2022 онд дутуу хийгдсэн "Ахуйн үйлчилгээний барилга" -ын ажлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн тодотголоор сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад нэмж тусган ИТХ-аар батлуулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.	2023 оны 9 сарын 19-ны өдөр танилцуулж сонсох ажиллагаа явуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн.	Зөрчлийг давтан гаргуулахгүй таслан зогсоох албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх	Засаг дарга, Нягтлан бодогч	Б.Өлзийшиг, Э.Сумьяажаргал
2	Хөрөнгийн зардал	Сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн "Төв саадны тохижилт, засвар", "Спорт талбайн тохижилт", "Хөдөөгийн 3 багц Мал угаалгын банн шинээр барих" ажлын захиалагчийн мөргөжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй.	2,697,458.00	Захиалагчийн хяналтыг мөргөжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй нь холбогдох хууль, журмыг зөрчиж байх тул зөрчлийг таслан зогсоож, дуусаагүй ажлын хяналтыг хууль журмын дагуу гүйцэтгүүлж зөрчлийг арилгах.	2023 оны 9 сарын 19-ны өдөр танилцуулж сонсох ажиллагаа явуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн.	Зөрчлийг давтан гаргуулахгүй таслан зогсоох албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх	Засаг дарга, Нягтлан бодогч	Б.Өлзийшиг, Э.Сумьяажаргал
3	Хөрөнгийн зардал	Хөдөөгийн 3 багц Мал угаалгын банн шинээр барих" 3 багц ажлын тендер шалгаруулалтын хууль, журмын дагуу зохион байгуулаагүй.	95,550,270.00	Мал угаалгын банн шинээр барих ажлыг газар зүйн байрлалыг харгалзан 3 багц болгон хуваасан боловч тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгоогүй зөрчлийг таслан зогсоох.	2023 оны 9 сарын 19-ны өдөр танилцуулж сонсох ажиллагаа явуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн.	Зөрчлийг давтан гаргуулахгүй таслан зогсоох албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх	Засаг дарга, Нягтлан бодогч	Б.Өлзийшиг, Э.Сумьяажаргал
		<b>дүн</b>	<b>132,511,442.00</b>						

Балтгэсэн: Ахлах аудитор

Хянасан: Аудитын менежер

Хоёр дах шатанд хянасан: Дарга тэргүүлэх аудитор

Д.Ихбаяр

Х.Наранцагвайн

Р.Мөнхтогтох

Засаг дарга

Засаг даргын орлогч

Санхүүгийн албаны дарга

Б.Өлзийшиг,

Э.Энхжаргал

Б.Доржсанд

Э.Сумьяажаргал

Нягтлан бодогч